



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/2022

Чингис хот

Коронавирусын халдвар (ковид-19)
цар тахлын болзошгүй эрсдэлийг бууруулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 37 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирусын халдвар (ковид-19)-ын тохиолдол бүртгэгдсэн Хэрлэн сумын эрүүл мэндийн байгууллагуудын 2-р ээлжинд зарцуулсан хоол хүнс, шатахууны зардалд зориулж хөрөнгө зарцуулсугай.
2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах 5,307,632 (таван сая гурван зуун долоон мянга зургаан зуун гучин хоёр) төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т зөвшөөрсүгэй.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011444

05 Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 06 өдрийн 3/202
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр төрөл	Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн газар	Өрхийн Эрүүл мэндийн төв	Нийт дүн
1	Хоол хүнс	3,307,577			3,307,577
2	Шатахууны зардал	358,500	1,243,900	397,655	1,999,855
	НИЙТ ДҮН	3,666,077	1,243,900	397,655	5,307,632